



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/158

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV хуралдааны XXV/05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн цэргийн албан хаагчдын орон сууцны засварын ажлын 45,000,000 (дөчин таван сая) төгрөгийг захиран зарцуулах эрхийг ангийн захирагч (Хурандаа Г.Эрдэнэбаяр)-д олгосугай.

2.Эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч (Хурандаа Г.Эрдэнэбаяр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардлагатай хөрөнгийг 2024 оны батлагдсан хөрөнгө оруулалтын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

